



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн товч мэдээлэл.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.3 Төслийн хүчин чадал.....	5
1.4 Төслийн бүтээгдэхүүн гаргалт	6
1.5 Төслийн хүдэр баяжуулах технологи	6
1.6 Төслийн дэд бүтэц.....	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл.....	9
2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч	9
2.3 Ургамлан нөмрөгийн төлөв байдал.....	10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	12
БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт	15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	
БҮЛЭГ 6. БИОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	25
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1 Төслийн талбайн байршил	4
Зураг №. 2 төслийн талбайн өнөөгийн байдал	4
Зураг №. 3 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	6
Зураг №. 4 Баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт	8
Зураг №. 5 Төсөл хэрэгжих талбайн рельеф	9
Зураг №. 6 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал.10	
Зураг №. 7 Төслийн талбайд зонхилох ургамал	10
Зураг №. 8 Төслийн нөлөөллийн эрчим.....	12
Зураг №. 9 Хөрсний газрын гадаргын температур	13
Зураг №. 10 Төсөл хэрэгжих талбайн ургамлын тархалт	13

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	3
Хүснэгт №. 2 Үйлдвэрийн бутлах цехийн ажиллах горим.....	5
Хүснэгт №. 3 БОМТ-ний зардалын задаргаа	16
Хүснэгт №. 4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт №. 5 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	20
Хүснэгт №. 6 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	21
Хүснэгт №. 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	23



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
Хүснэгт №. 9 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга	27
Хүснэгт №. 10 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад.....	28
Схем №. 1 Жонш баяжуулах технологийн схем.....	7





ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч мэдээлэл

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших Э-1804000274, Э-1804000276 дугааруудтай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй Хайлуур жоншны баяжуулах үйлдвэрийн төслийн техник эдийн засгийн үндэслэлийг 2021 оны 04 сарын 13-ны өдрийн Т/21-06-07 тоот дүгнэлтийг үндэслэн 2021 оны 05 сарын 21-ны Т/95 дугаар тушаалаар батлуулсан байна.

Баяжуулах үйлдвэр нь жилд 100 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай бөгөөд СаF₂-ийн агуулгыг дунджаар 97%, жонш авалтыг 87.0%, ФФ-97 маркийн өндөр чанарын флотацийн баяжмал авах боломжтой гэж хүдэр баяжуулах технологийн схем сонгосон байна. Уг төслийг хэрэгжүүлснээр 94 хүний ажлын байр бий болж, 1 ажилчны сарын дундаж үндсэн цалинг 1,580.0 мян.төг байхаар төлөвлөсөн байна. Байгаль орчныг хамгаалах зардалд нийт 705.2 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс техникийн нөхөн сэргээлтийн ажилд нийт 33.0 сая төгрөг төсөвлөсөн ба биологийн нөхөн сэргээлтийн ажилд 28.3 сая, зам арчилгаанд 100.0 сая төгрөг, хаалт, мониторингийн зардалд 236.2 сая төгрөг, байгаль орчин хамгаалахад 307.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Бор-Өндөр мандал” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011815200
Регистрийн дугаар	6530044
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 7-р хороо, 11-р хороолол, эрхүүгийн, 10, 87,
Утас	99134747

“Төслийн байршил: Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших бөгөөд Бор-Өндөр сумын төвийн урд хэсэгт 3 км, Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 320 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос баруун урд зүгт 200 км-т оршино. Төсөл хэрэгжих талбай нь Бор-Өндөр сумын засаг даргын захирамж 2020 оны 09-р сарын 21-ны өдрийн А/146 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 2322002976, 2322002979 дугаарууд бүхий нийт 5 га газрыг “Бор-Өндөр мандал” ХХК нь үйлдвэрлэлийн зориулалтаар Э-1804000274, Э-1804000276 дугааруудтай газар эзэмших эрхийн гэрчилгээг эзэмшдэг бөгөөд хайлуур жоншыг баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна. Төсөл хэрэгжих талбайн газарзүйн солбилцолыг доорхи хүснэгтээр орууллаа.

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжих талбайн солбилцол


№	Нэгж талбарын №2322002976		Нэгж талбарын №2322002979	
	X	Y	X	Y
1	378566.06	5121425.78	378448.87	5121563.00
2	378784.79	5121601.54	378495.43	5121508.48
3	378713.40	5121680.53	378713.40	5121680.53
4	378495.43	5121508.48	378664.39	5121734.75



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг №. 2 төслийн талбайн өнөөгийн байдал



Зураг №. 1 Төслийн талбайн байршил



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.3 Төслийн хүчин чадал

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Бор-Өндөр мандал” ХХК-нийн хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь жилд нийт 100.0 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай байна.

Баяжуулах үйлдвэр нь бүтэн жил тасралтгүй ажиллагаатай байх төлөвлөгөөт ба урсгал засварын, мөн цаг агаарын гэнэтийн саатлыг тооцож жилд 300 хоногт хэвийн үйл ажиллагаа явуулахаар ТЭЗҮ-д тооцсон байна.

Баяжуулах үйлдвэрийн технологийн процесс нь тасралтгүй ажиллагаатай байх шаардлагатай ба үйлдвэрийн ажилчдын хөдөлмөр зохион байгуулалтыг 2 ээлжээр төлөвлөсөн. Бутлах цех нь 2 ээлжээр 8 цагаар, төв корпус (нунтаглах, баяжуулах цех) нь 2 ээлжээр, 11 цагаар, тасралтгүй ажиллана.

Хүснэгт №. 2 Үйлдвэрийн бутлах цехийн ажиллах горим

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12
3	Жилийн хуанлийн цаг	8760
4	Өдрийн хуанлийн цаг	24
5	Ээлжийн тоо	2
6	Хоногт ажиллах цаг	11
7	Төлөвлөгөөт засварын хоног	30
8	Урсгал засварын хоног	35
9	Жилд ажиллах бодит өдөр	300
10	Жилд ажиллах бодит цаг	7200
11	Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, %	93
12	Жилд ажиллах бодит цаг	6666
13	Сард ажиллах бодит цаг	556
14	Цагийн хүчин чадал, тн/цаг	15.0
15	Хоногийн хүчин чадал, тн/хоног	360
16	Сарын хүчин чадал, тн/сар	8333
17	Жилийн хүчин чадал, тн/жил	100,000



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж

Том бутлалтад PE400x600, жижиг бутлалтад PEX250x1200 маркийн хацарт бутлуур, шигшилтэд 2YA-1536 маркийн доргиурт шигшүүр, нунтаглалтад MQ-2200x4000 маркийн бөмбөлөгт тээрэм, ангилалтад FG-2000 маркийн мушгиа ангилуур, флотацийн үндсэн, цэвэрлэгээний болон хяналтын баяжуулалтад SF-2.8 маркийн флотомашин 33 ширхэг, баяжмал усгүйжүүлэлтэд NZ-12 маркийн өтгөрүүлэгч, GW-12 маркийн вакуум шүүлтүүр тус тус ашиглахаар төсөлд тусгасан байна.



Зураг №. 3 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж

1.4 Төслийн бүтээгдэхүүн гаргалт

Баяжуулах үйлдвэр нь жилд 100 мян. тн хүдэр боловсруулж, 38.04 мян.тн ФФ-97 маркийн баяжмал үйлдвэрлэнэ. Баяжуулах үйлдвэрээс жилд 58.05 мян.м3 хаягдал гарна.


1.5 Төслийн хүдэр баяжуулах технологи

Бутлалт: Уурхайгаас ирэх хүдрийг анхан шатны хацарт бутлуурын өмнөх үл хөдлөх урьдчилсан шатны шигшүүрт дугуйт ачигчаар тэжээнэ. Бутлах цех нь II шатны бутлалт, I шатын хяналтын шигшилттэй. Бутлалтын I, II шатанд хацарт бутлуур хэрэглэнэ. Эхний шатны хацарт бутлуурын хүлээн авах хүдрийн хамгийн том ширхэглэл 350 мм байх бөгөөд бутлагдсан хүдрийн хамгийн том ширхэглэл нь 87.5 мм хүртэл байх ба, хоёрдугаар шатны хацарт бутлуураар 15 мм хүртэл бутлан чичиргээт шигшүүрээр шигшин +15 мм ангиллыг II шатны хацарт бутлуурт бутлан эргэлтийн ачаалал болгон чичиргээт шигшүүрт тэжээнэ. Чичиргээт шигшүүрийн доод бүтээгдэхүүн буюу -15 мм ангилал нь туузан конвейероор дамжин бутлагдсан хүдэр хураах талбайд хураагдана.



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нунтаглан баяжуулах хэсэг: Бутлагдсан хүдрийг дугуйт ачигчаар нунтаглалтын өмнөх бункерийг тэжээнэ. Бутлах хэсэгт бутлагдсан -15 мм ширхэглэлтэй хүдрийг бөмбөлөгт тээрэмд P80-74мм болтол нунтаглах бөгөөд нунтаглагдсан хүдрийг мушгиа ангилагчаар ангилж элсийг эргэлтийн ачаалал болгон бөмбөлөгт тээрэмд тэжээнэ. Тээрмийн эргэлтийн ачаалал 150% байна. Мушгиа ангилагчийн халиаг үндсэн флотацийн процессын өмнөх холигч ганд тэжээнэ. Үндсэн флотацийн баяжмалыг 6 шатны цэвэрлэгээний флотациар баяжуулан баяжмалыг өтгөрүүлэгч болон вакуум шүүн шахагчаар шахаж ФФ-97 маркийн флотацийн баяжмал гарган авна. Харин хаягдлыг 1 шатны хяналтын флотациар баяжуулан баяжмалыг эргүүлэн үндсэн флотацид тэжээх ба хяналтын флотацийн хаягдлыг өтгөрүүлж, өтгөрсөн хаягдлыг шүүж хаягдал хураах талбайд автосамосвалаар тээвэрлэн хаяна.



Схем №. 1 Жонш баяжуулах технологийн схем

1.6 Төслийн дэд бүтэц

Үйлдвэрийн барилга байгууламж: Баяжуулах үйлдвэр, химийн бодисын агуулах, хаягдлын сангийн байгууламж, засвар механикийн хэсэг, үйлдвэрийн лаборатори зэрэг барилга байгууламж байна.



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг №. 4 Баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт

Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамж: “Бор-Өндөр мандал” ХХК өөрийн хөрөнгөөр 2020 онд 110/35/6кВ Бор-Өндөр дэд станцын ячейк №4 Цэвэрлэх 6 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын анкер тулгаар №61-ээс салбарлан шинээр 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар татахаар цахилгаан хангамжийн асуудлыг бүрэн шийдсэн байна.


Усан хангамж: Технологийн усны хэрэглээг Бор өндөр хот тохижилт ОНТҮГ азартай хамтран ажиллах гэрээний дагуу саарал усаар хангах гэрээ хийсэн бөгөөд унд ахуйн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангахаар байна.



БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

Монгол орны физик газарзүйн мужлалаар хээр ба говийн их мужийн шилжилтийн заагаар орших агаад цав толгодлог, ухаа гүвээт гэсэн хоёр төрлийн рельеф зонхилдог. Цав толгодлог рельефийн үнэмлэхүй өндөр нь баруун хойноосоо зүүн урагшлах тутам аажим намсаж 1214,6-1481,2 м-ийн хооронд хэлбэлзэх ба ихэвчлэн бөмбөгөрдүү орой, налуу хажуутай байдаг. Дээр дурьдсан тухайн нутгийн ноёлох өндөрлөгөөс гадна Лог-уул, Өндөр зараа толгой зэрэг сөнөсөн галт уул нь харьцангуй эгц хажуутай байна. Ухаа гүвээт талархаг рельеф нь цэрд, юрын хурдас тархсан Янзагын тал, Төгрөгийн ухаа, Яшилын хоолой зэрэг 1,152.2-1,369.8 м өргөгдсөн нутгуудад зонхилон тархжээ. Харьцангуй өндөр нь 10-30 м байдаг. Ийм төрлийн рельеф нь гуу жалгаар харьцангуй бага хэрчигдсэн байдаг.



Зураг №. 5 Төсөл хэрэгжих талбайн рельеф

2.2 Хөрс, хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрс газарзүйн мужлалаар цөлөрхөг хээрийн бүсэд хамаарах бөгөөд нам толгодын ухаа хүрэн хөрс тархсан байна. Хөрсний шинж чанарын хувьд маш сийрэг, чийгийн хангамж багатай, чулуурхаг цайвар бор өнгийн хээрийн хэв шинжэд хамаарах элсэрхэг хөрс зонхилсон, хөрс нь байгалийн элэгдэл эвдрэлд өртсөн, хүний болон техникийн нөлөөнд бага зэрэг өртсөн байна.



Зураг №. 6 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал

2.3 Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамал зүй: “Теем смайл” ХХК-ны судалгааны баг 2021.03.01-нд төслийн талбайд очиж судлан ургамлан бүрхэвчийг шинжэхэд талбай нь ургамлын бүрхэвчээр сийрэг тачир ургамал ургадаг. Тал хөндий, энгэр бэл газраар таана, хөмүүл, агь зэрэг говийн шимт ургамлаас гадна шарилж, зангуу ургах ба толгодын орой, хажуугаар хялгана, хазаар өвс, монгол өвс зонхилно. Бутлаг ургамлаас бор харгана, алтан харгана, дэрс голлох ба Яшил, Билгэх, Буянтын хяраар буйлс, мөнх ногоон зээргэнэ, хужир марзтай шаварлаг хөрсөнд бор бударгана, улаан бударгана, зарим газар хармаг ургасан байна.



Зураг №. 7 Төслийн талбайд зонхилох ургамал



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ус зүй: Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ муу хөгжсөн ба байнгын урсгал ус байхгүй. Ордын орчимд гол, булаг шанд байхгүй бөгөөд олон тооны хуурай сайрууд тохиолдох ба эдгээр нь нилээд хэдэн километр үргэлжилдэг. Бороо элбэг ороход хуурай сайруудад түр зуурын урсгал ус бий болдог.

Ан амьтан: Энэ районд араатан, өвсөн тэжээлтэн, мэрэгчид, шавьж, хэвлээр явагчид, жигүүртэн зэрэг амьтан амьдардаг. Үнэг, хярс, мануул, дорго, ховроор чоно зэрэг араатан, өвсөн тэжээлтнээс хар сүүлт, хадархаг газраар янгир, /Яшиллын хярд/ талбайн хойд хэсгээр тарвага бий. Төрөл бүрийн хулгана, алаг даахай зэрэг мэрэгчид, хэвлээр явагчдаас могой, 2 төрлийн / хонин, могойн / гүрвэл, шавьжаас голио, царцаа, дэвхрэг жигүүртнээс сар, элээ, харцага, болжмор, ногтруу зэрэг нутгийн шувууд байдаг. Дулааны улиралд усны шувууд нүүдэллэн ирээд намрын сард дулаан орон руугаа буцдаг.

Уур амьсгал: Төсөл хэрэгжих талбайн эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай хоног, сар, жилийн температурын хэлбэлзэл нь их байдаг. Хүйтний эрч нэг хоёрдугаар сард 15° - 32.6° хүрнэ. Хур тунадасны ихэнх нь зуны адаг, намрын эхэн, дунд саруудад унах бөгөөд хэмжээ нь 80.5 мм-ээс хэтэрдэггүй. Зун нь нилээд халуун болж сарын дундаж температур нь $+23^{\circ}$ орчим байдаг. Хаврын улиралд хүчтэй салхилах бөгөөд заримдаа цасан болон шороон шуурга шуурдаг. Салхины голлох чиглэл нь баруун хойд, хойд зүгээс зүүн өмнө, өмнө зүг салхилна. Анхны цас 9-р сарын сүүлчээр унаж, 4-р сарын эхээр хайлж дуусна. Хээрийн ажил явуулах тохиромжтой хугацаа нь 5-6-р сар юм.


Агаарын чанар: Тухайн орчинд байгалийн болон антропологийн гаралтай агаарын бохирдлын ямар нэг илрэл байхгүй бөгөөд цаашид энэхүү цэнгэг агаартай орчны унаган төрхийг хадгалан өөрсдийн эрхлэх үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа дэвшилтэт арга технологи ашиглах нь зүйтэй.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Бор-Өндөр мандал” ХХК-ны хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагаа хэрэгжснээр тухайн үйлдвэрийн бүс тодорхой хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь үйлдвэрийн барилга байгууламж, хаягдлын сан, ажилчдын тосгон, хүнд даацын машины хөдөлгөөн зэрэг юм.

Мөн төсөл хэрэгжиснээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.




Зураг №. 8 Төслийн нөлөөллийн эрчим

Төслийн үйл ажиллагаанаас хамааран хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийг тооцоолон ArcGIS 10.8 программд зураглахад 300 метрийн радиуст нөлөөллийн эрчим их буюу хүчтэй, 500 метр радиуст нөлөөллийн эрчим дунд буюу саармаг, 800 метрийн радиуст нөлөөллийн эрчим бага буюу сул байна.




ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг №. 10 Төсөл хэрэгжих талбайн ургамлын тархалт

Landsat 5 хиймэл дагуулын мэдээг ашиглан төслийн талбайн ургамлын тархалтын зураглалыг ArcGIS 10.8 программд зураглахад төсөл хэрэгжих талбайн ургамалжилтийн индекс нь тахлагдлын хэмжээ бага зэргийн ургамалтай /0.2-0.3 / ба дунд зэргийн ургамалтай /0.3-0.4/ ангилалд багтаж байна.



Зураг №. 9 Хөрсний газрын гадаргын температур



Байгаль орчинд: Төслийн үйл ажиллагаанаас 39 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 3 буюу 7.1% нь “бага”, 19 буюу 45.2% нь “дунд”, 18 буюу 42.8% нь “их”, 2 буюу 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Эндээс үзэхэд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ дундаас их хэмжээнд байхаар байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ агаарын чанарт 19%, газрын гадарга, хэвлийд 19%, хөрсөн бүрхэвчид 17%, газрын доорх усанд 15%, ургамлан нөмрөгт 15%, амьтны аймагт 15% гэсэн үзүүлэлт гарч байгаа ба газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл илүү байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга:

- ✂ Маршрутын бус замаар бүтээгдэхүүн тээвэрлэхгүй байх.
- ✂ Үйлдвэрийн ажилчдад байгаль орчинг хамгаалах сургалт, сурталчилгаа явуулах
- ✂ Төсөл хэрэгжиж дууссаны дараа төлөвлөгөөний дагуу хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг явуулах
- ✂ Таних тэмдэг, дохиогоор тэмдэгжүүлэх
- ✂ Түлшээр ажилладаг тоног төхөөрөмжүүдээс ялгарах утааны хэмжээг хянаж, яндангийн шүүр зэргийг тогтмол шалгаж, эвдэрсэн эд ангийг шинэчилж байх
- ✂ Үйлдвэрлэл үйл ажилгааны нөлөөгөөр үүсэх тоосжилтоос урьдчилан сэргийлж чийглэж байх
- ✂ Бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийг зөвшөөрөгдсөн замаар явуулах
- ✂ Тогтоогдсон стандартад нийцсэн машин механизмыг ашиглах

Хүний эрүүл мэндэд: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, тэсэлгээ, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдал зэрэг үйлдвэрийн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

Нийгэм эдийн засагт: Төсөл хэрэгжих суманд ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах, төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулах, зэрэг ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.



БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Бор-Өндөр мандал” ХХК-ийн “Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд:

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;
2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо.

Тус төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ,



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР
ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөнсэргээлтийн төлөвлөгөө болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 3 992 000 төг зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Хүснэгт №. 3 БОМТ-ний зардалын задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	900,000
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	650,000
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,000 000
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	598 000
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	320 000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	182 000
8	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	150 000
9	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200 000
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		4,000,000



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
								2023 он	
1	Агаарын чанар								
	Баяжуулах үйлдвэрийн дотоод замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Үйлдвэр дотор замыг тэмдэгжүүлж, хүдэр буулгах талбай хэсгийг зохист ширхэглэл бүхий хайргаар дүүргэн дэвсэж нягтруулан тоосжилтыг бууруулах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа усалж байх	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 Бензинхөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Үйлдвэрт ашиглагдах бүх төрлийн тоног төхөөрөмж машин механизмд үзлэг оношлогоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	
		Үйлдвэрийн ажилчид нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт болон хор саармагжуулах бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	
2	Хөрсөн бүрхэвч								



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Үйлдвэрийг зөвшөөрлөөр олгогдсон талбайд үйлажиллагааявуулах, хил хязгаарыг хашаажуулах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	“Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх, сул шороо бүхий газруудаас тоос босох	Төслийн талбай дахь сул шороо бүхий газруудыг ургамалжуулах, мод бут тарих	Төслийн талбайд	-		-	Нөхөн сэргээх арга хэмжээнд тусгав	+	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS
	Хөрсөнд шатах тослох материалаар бохирдуулах	Хөрсөнд тос масло асгахгүй үүднээс авто машинийг тусгай бэлдсэн талбай бэлдэх							
3	Усны нөөц, усны чанарт								
	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд	Ногоон байгууламжийн усалгаанд ашиглах усыг хэмнэлттэй хэрэглэх	Төсөл хэрэгжих талбайд	-		-	Ү.а-ны зардлаар	+	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай тусгаж өгөх		Ажилчдад	-		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	+	Усны тухай хууль MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус	
Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худагаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг		Ажилчдын байрны хүрээнд	-		-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Сард 1 удаа	ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/	



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	сөргөөр нөлөөлж болзошгүй.	тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх							
		Ус ашиглалтын гэрээг Умард говийн гүвээт халхын дундад талын сав газартай хийх							
4	Амьтны аймаг, ургамлан нөмрөг								
	Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Хог хаягдалыг ил задгай хаяхгүй байх	Үйлдвэрийн хог хаягдлын хүрээнд	-		-	Хог хаягдлын менежментийн зардалд	+	Хог хаягдлын тухай хууль 2017 он
		Төслийн ажилчид хууль бусад агнуур хийхгүй байх	Үйлдвэрийн хүрээнд	-		-	300.0		
	Нийт		900,000						



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
1	Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм.	Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон орхигдсон 2.5 га-аас багагүй талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны дуусмагц	–	–		Үйл ажиллагааны зардлаар	–	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
Нийт 2.0									



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 7.БИОЛОГИЙН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 5 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2023		
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ							
1		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 0.15 га газар 150 ширхэг мод тарихаар төлөвлөсөн	Үйл ажиллагааны эхэнд	-	2023	Үйл ажиллагааны зардлаар	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
Нийт дүн, мян.төг			650 000 төг				



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд тухайн төслийн үйлдвэрлэлийн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Үйлдвэр ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол үйлдвэрийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 6 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2023 он	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	2	150		2023 он	
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх,	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших		-				
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах, ажилчдын ХАБЭА-н зааварчилгаа өгсөн бүртгэлийг хөтлөх		12				
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх		-		220	2023 он	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны		-				



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

байгалийн гамшиг	алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах				
	Хаягдлын даланг хашаажуулан, тэмдэг тэмдэглэгээ хийх	-			
	Үйлдвэрийн бүсэд хөдөлмөр аюулгүй байдлын иж бүрэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	-			
Эрүүл мэнд	Ажилчдыг ажлын хувцас хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, бээлий, хамгаалалтын нүдний шил маск) хангах	Бүх ажилчдад	200.0	2023 он	
	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Төслийн нийт хугацаанд	220.0	2023 он	
Нийт зардал (мян.төг)			598 000 төг		



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2023 он	
Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдол	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш				50.00	2023	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Төслийн талбайн бүх барилга байгууламжуудад				Үйл ажиллагааны зардлаар	2023	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасанаар	2023	MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Стандарт нийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд				125.00	2023	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчидын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар төлөвлөн байгуулах, үүссэн шингэн хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Ахуйн хаягдлын хүрээнд				50.0	2023	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдолоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. Гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх.					155.0		
	Үйлдвэр болон кемпийн барилгад агааржуулалтын систем суурьлуулах							
Нийт	320 000 төг							



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт №. 8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээний байршил	Хугацаа ба давтамж 2023 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	109°25'45.05"E 46°14'19.83"N	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	25.0*2	1 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /25.0/ НИЙТ 50.0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 25.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисынхэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээжавахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисынхэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	1 цэгт /Засварынцех, ШТС/ 109°25'32.00"E 46°14'12.64"N	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	20.0*2	1 цэгт х 1 дээж х жилд 2 удаа х 1 жил х 25,0 Нийт 50,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 25.0 төг/	
Усны хяналт шинжилгээ								



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2	Усны түвшин усны ундарга нөөц	Төслийн талбай орчим Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн байршил 109°25'27.78"E 46°14'8.20"N	2023 он	Жилд 2 удаа	46.0*2	46.0*2 удаа х 1жил НИЙТ 92.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3				2023 он				
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН								



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 9 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2023 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Үйлдвэрийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Үйлдвэрийн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2023 он
7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах	Үйлдвэрийн хэмжээнд	-	250.00	2023 он
9	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Үйлдвэрийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
10	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Үйлдвэрийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				150 000төг	



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БҮСИЙН ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 10 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутгийн оршин суугч болон засаг захиргааны байгууллагад танилцуулж хэлэлцүүлнэ.	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2023 оны 11-р сар	150.0	БО-ны мэргэжилтэн, үйлдвэрийн дарга	Сумын иргэдийн нийтийн хурлын танхим, төсөл хэрэгжүүлж буй газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг Бор-Өндөр сумын БОГазарт танилцуулж хэлэлцүүлнэ.	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2023 оны 11-р сар	150.0	БО-ны мэргэжилтэн, уурхайн дарга	
Нийт		200 000 мян.төг				